



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/344

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6, 25 дугаар зүйлийн 25.1.10, Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мал, амьтны гоц халдварт өвчний үед онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагааг зохион байгуулах заавар"-ыг 1 дүгээр, нөхцөл байдлын мэдээний загварыг 2 дугаар, тарилгын мэдээний загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан зааврыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын штабын дарга /дэд дарга/ (онцгой байдлын хурандаа Г.Ариунбуян)-д даалгасугай.

ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2015 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн А/344  
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ҮЕД ОНЦГОЙ БАЙДЛЫН  
БАЙГУУЛЛАГА БОЛОН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН ХАРИЛЦАН  
АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврын зорилго нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хор уршгийг арилгах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагааг зохицуулахад оршино.

**Хоёр. Нэр, томъёоны тодорхойлолт**

2.1. Дараах нэр, томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. "Малын өвчинтэй тэмцэх", "Гоц халдварт өвчин", "Хорио цээр тогтоох", "Өвчтэй болон халдварын голомтод байгаа малыг зайлшгүй шаардлагаар нядлах, устгах" гэсэн нэр томъёог Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар;

2.1.2. "Шүлхий", "Боом", "Гахайн сонгомол мялзан", "Хонь, ямааны цэцэг", "Хорт салст халуурал" гэсэн нэр томъёог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/86 дугаар тушаалын хавсралтад зааснаар тус тус ойлгоно.

**Гурав. Харилцан ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх ажил:**

3.1. Мал, амьтны гоц халдварт өвчний үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг албан тушаалтны санал, дүгнэлтийг үндэслэн нутгийн захиргааны байгууллагын шийдвэрээр үйл ажиллагааг зохион байгуулах;

3.2. гоц халдварт, халдварт өвчинд мэдрэмтгий малын тоог бодитой гаргах, шаардлагатай вакцин, холбогдох багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг захиалах;

3.3. урьдчилан сэргийлэх вакцинийг гоц халдварт, халдварт өвчин оношлогдсоноос хойш нэн даруй голомтын бүсэд хүргүүлэх;

3.4. уг зааврын 1, 2 дугаар хавсралтын дагуу мал, амьтны гоц халдварт өвчний нөхцөл байдлын мэдээ, тарилгын мэдээг хийж Онцгой байдлын байгуулагад ирүүлэх;

3.5. хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангах, нөхөн олговрын үнэлгээ, тооцоог гаргах.

**Дөрөв. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хэрэгжүүлэх арга хэмжээ:**

4.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Онцгой комисс:

4.1.1. гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай зардлыг шийдвэрлэх;

4.1.2. гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;

4.1.3. халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүнийг үүрэг гүйцэтгэх нөхцөл боломж, тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгсэл, техник багаж хэрэгслээр хангах;

4.1.4. голомтын бүсэд хүнс, өргөн хэрэглээний болон бусад шаардлагатай барааны хангалтыг зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, хуваарилах;

4.1.5. шаардлагатай тохиолдолд баяр, наадам, урлаг, соёл, спортын уралдаан тэмцээн гэх мэт нийтийг хамарсан арга хэмжээг зогсоох, хойшлуулах шийдвэр гаргах;

4.1.6. шаардлагатай тохиолдолд хүн хүч, техник хэрэгслийг дайчлах, хүн ам, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх;

#### **4.2. Онцгой байдлын алба:**

4.2.1. Онцгой комиссын хурлын бэлтгэлийг хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

4.2.2. гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

4.2.3. шинжилгээ хийхээр авсан дээжийг яаралтай, түргэн шуурхай тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.2.4. зориудаар устгах мал, амьтан болон хорогдсон малын сэг зэмийг устгах, булшлах, халдваргүйтгэх үйл ажиллагааг холбогдох гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангитай хамтран зохион байгуулах;

4.2.5. хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлийг холбогдох гамшгаас хамгаалах албадтай хамтран зохион байгуулах;

4.2.6. хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт зорчих зөвшөөрөл олгох, уг бүсэд нэвтэрсэн, гарсан болон дайран өнгөрсөн хүн, автомашины бүртгэлийг дэлгэрэнгүй хөтлөх;

4.2.7. хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангах, нөхөн олговрын үнэлгээ, тооцоог гаргаж Улсын онцгой комисст хүргүүлэх;

4.2.8. голомтод үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд сахиулах;

4.2.9. Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, холбогдох албан тушаалтныг мэдээ мэдээллээр тухай бүр шуурхай хангах, нөхцөл байдлыг байрзүйн зурагт оруулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэж, өдөр тутам Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлэх.

### **4.3. Гамшгаас хамгаалах Хүнс, хөдөө аж ахуйн алба:**

4.3.1. лабораторийн шинжилгээний хариуг үндэслэн өвчтэй малыг хяналтад авах, тусгаарлах, эмчлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, нядлах, устгах тухай саналыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Онцгой байдлын байгууллагад уламжлах;

4.3.2. Засаг даргын захирамжаар тогтоосон хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэх, өвчний тархалт, хүрээ, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хил залгаа аймаг, сум, багийн малын эмч нарт мэдэгдэх, харилцан мэдээлэл солилцох, болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.3.3. гоц халдварт өвчний хорио цээрийн бүсэд мөрдөх дүрэм, журам, заавар, стандарт, ариун цэврийн дэглэмийг шуурхай хэрэгжүүлэх;

4.3.4. доод шатны мал эмнэлэг, үржлийн албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

4.3.5. малын гоц халдварт өвчинтэй тэмцэх мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийн талаар иргэд, олон нийтэд сурталчлах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмж өгөх;

4.3.6. малын арчилгаа, тэжээллэгийн нөхцлийг сайжруулах, байнгын хариулгатай болгох;

4.3.7. ариутгалын цэгээр дамжин өнгөрөх хүн, тээврийн хэрэгслийг стандартын дагуу ариутгах;

4.3.8. өвчилсөн мал, амьтны хашаа, саравч, байр, тоног хэрэгслийг ариутгал халдваргүйтгэлийн бодис, бэлдмэлээр халдваргүйтгэх;

4.3.9. мал, амьтанд нэг бүрчлэн эмнэлзүйн үзлэг хийж өвчтэй мал, амьтныг ялгаж тусгаарлах;

4.3.10. ариутгал, халдваргүйтгэлийн суурин болон зөөврийн цэг байгуулах;

4.3.11. вакцинд хамрагдах мал, амьтны тоог бодитой гаргах, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх;

4.3.12. урьдчилан сэргийлэх вакцинийг гоц халдварт өвчин гарснаас хойш 5 хоногт багтаан голомтын бүсэд хүргүүлэх;

4.3.13. нэг малын эмч өдөрт 800-1000 толгой бог мал, эсхүл 150-180 толгой бод мал урьдчилан сэргийлэх вакцинд хамруулахаар тооцох, төлөвлөх;

4.3.14. урьдчилан сэргийлэх вакцинийг зааврын дагуу тарих;

4.3.15. өвчний улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг халдваргүйтгэл хийж устгах;

4.3.16. өвчний голомт дахь айл өрх, фермд мал, амьтны гаралтай түүхий эдийн шилжилт, хөдөлгөөн /мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир г.м/ хийлгэхгүй байх, хяналт тавих.

#### **4.4. Гамшгаас хамгаалах Мэргэжлийн хяналтын алба:**

4.4.1. хорио цээрийн дэглэм тогтоох дүгнэлтийг гаргах, хэрэгжилтэд хяналт тавих;

4.4.2. Засаг даргын захирамж болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй албан тушаалтан, иргэнд хариуцлага тооцох;

4.4.3. өвчилсөн мал, амьтныг устгах, булшлах, ариутгал халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, стандартыг мөрдүүлэх, дүгнэлт гаргах;

4.4.4. өвчилсөн болон хорогдсон малын түүхий эдийг худалдан борлуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавих;

4.4.5. мал, амьтныг дархлаажуулах вакцинийг тээвэрлэх, ачих, буулгах, хүлээлцэх, баталгаат хугацаа болон хадгалалтын горим, вакцинжуулалтын үйл ажиллагаа, ариутгал халдваргүйтгэл хийх байршил, уусмал, тунгийн хэмжээ, найрлагад хяналт тавих, дүгнэлт гаргах;

4.4.6. халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хамгаалах хувцас, хэрэгслийг тогтоосон дарааллын дагуу өмсөх, тайлах, ариутгах, устгахад хяналт тавих;

#### **4.5. Гамшгаас хамгаалах Хэв журам сахиулах алба:**

4.5.1. халдварт өвчний голомт, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

4.5.2. ариутгал, хяналтын цэгээр дамжин өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийг бүртгэх, голомтын бүс орчмын зорчих хөдөлгөөний замын зураглал гаргах, явах чиглэлийг тодорхойлох, зорчих хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих;

4.5.3. голомтын бүсэд гаднаас мал, амьтан оруулах болон гадагш гаргахгүй байх, хяналт тавих.

#### **4.6. Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн алба:**

4.6.1. голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн албан хаагчдын болон голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтад авах;

4.6.2. шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

#### **4.7. Гамшгаас хамгаалах Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын алба:**

4.7.1. голомтын бүсэд байгаа малчин өрх айл, ферм, тэдгээрт амьдарч, ажиллаж байгаа хүн амын тоо, судалгаа гаргах;

4.7.2. шаардлагатай тохиолдолд голомтын бүсэд байгаа малчин өрх айлын их дээд, дунд сургуульд суралцагчдын мэдээ мэдээллийг гаргах, шилжилт хөдөлгөөнд зохицуулалт хийх саналыг Засаг дарга, Онцгой комисст танилцуулах.

#### **4.8. Гамшгаас хамгаалах Холбоо, зарлан мэдээллийн алба:**

4.8.1. голомтын бүсэд холбоог зохион байгуулах нөхцлийг бүрдүүлэх, шаардлагатай техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, аюулгүй ажиллагаанд хяналт тавих.

#### **4.9. Гамшгаас хамгаалах Түлш, эрчим хүчний алба:**

4.9.1. голомтын бүсэд ажиллаж байгаа хяналтын цэгийг цахилгаанаар хангах, нөөц үүсгүүрийг бэлтгэх.

#### **4.10. Гамшгаас хамгаалах Зам тээврийн алба:**

4.10.1. хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрийн авто зам, даваа хаагдсан тохиолдолд яаралтай нээх, зам гаргах;

4.10.2. хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх улсын болон орон нутгийн чанартай авто замын зураглал гаргах, зохицуулалт хийх.

#### **4.11. Ус, цаг уур, орчны шинжилгээний алба:**

4.11.1. хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн цаг агаарын мэдээг нарийвчлан гаргаж Онцгой комисс болон голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнд мэдээлэх.

#### **4.12. Гамшгаас хамгаалах Барилга, хот байгуулалтын алба:**

4.12.1. аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, Онцгой байдлын газрыг шаардлагатай газрын зургаар хангах.

### **Тав. Бусад**

#### **5.1. Тагнуулын газар:**

5.1.1. Шаардлагатай тохиолдолд өвчин анх гарсан эх үүсвэр, халдвар тархсан нөхцөл байдлыг тогтоох, эрх бүхий албан тушаалтныг шаардлагатай мэдээллээр хангах.

## **5.2. Зэвсэгт хүчин, Хилийн ба дотоодын цэргийн анги,**

### **байгууллага:**

5.2.1. мал, амьтныг зориудаар устгахад шаардлагатай буу, сум, галт хэрэгслээр хангах, Онцгой комиссын шийдвэрээр зориудаар устгах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.2. өвчилсөн болон үхсэн мал, амьтныг устгах, ариутгал халдваргүйтгэл хийх, хорио цээрийн дэглэм сахиулах, нүүлгэн шилжүүлэлт хийх зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх.

### **5.3. Хүнсний зах, мах худалдаалдаг аж ахуйн нэгж, иргэн:**

5.3.1. хүнсний захад худалдаалж байгаа мах, дотор эрхтэн нь өвчнөөр тайван бүс нутгаас бэлтгэсэн болохыг баталсан гарал үүслийн гэрчилгээтэй байх;

5.3.2. хүнсний захад худалдаалах малын гулууз, толгойн тунгалагын зангилаанууд болон цуллагын эрхтэнд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг хийлгэх;

5.3.3. үзлэгээр халдварт өвчний сэжиг илэрвэл хүнсний захын үйл ажиллагааг зогсоож, хорио цээрийн арга хэмжээ авах;

5.3.4. лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан тохиолдолд халдваргүйтгэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

### **5.4. Иргэн, аж, ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг:**

5.4.1. мал, амьтан гэнэт олноор хорогдсон, халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд 12 цагийн дотор малын эмчид дуудлага өгөх;


5.4.2. мал эмнэлгийн үзлэг, урьдчилан сэргийлэх тарилгад мал, тэжээвэр амьтнаа бүрэн хамруулах, шаардагдах хашаа, байр, хүн хүчний дэмжлэг үзүүлэх, малыг байнгын хариулгатай байлгаж, арчилгаа маллагааг сайжруулах;

5.4.3. эрүүл, өвчтэй малыг тусгаарлах, малын эмчийн зөвшөөрөлгүйгээр шилжилт хөдөлгөөн хийхгүй байх;

5.4.4. мал, амьтны гоц халдварт өвчний талаар үнэн зөв мэдээлэл өгөх;

5.4.5. хорио цээрийн дэглэмийг чанд сахих, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг дагаж мөрдөх.

----oOo----



Мал, амьтны гоц халдварт өвчний үед  
Онцгой байдлын байгууллагын баримтлан  
ажиллах зааврын 2 дугаар хавсралт

МАЛ, АМЬТНЫ ХАЛДВАРТ, ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ

Аймаг /нийслэл/ /сум/ /дүүрэг/-ийн нэр.....

Огноо

д/ д	Өвчин гарсан			Өвчний нэр	Өрхи йн тоо		Голомт ын тоо	Өвчилс өн мал, амьтан		Засаг даргын захирагч, шийдвэрийн Хугацаа, дугаар	Учирс ан хохир ол		Хэрэгжүүлсэн арга хэмжээ			Гарсан зардал	
	Огноо	Аймаг, сум, баг	Координат		Том хүн	Хүүхэд		Төрөл	Тоо		Хорогдсон	Устгасан	Устгалын цэг	Хяналтын цэг	Вакцинуулсан	Ариутгал халдваргүйтгэл	Засгийн газраас
1																	
2																	
Н ий т																	

Гарын үсэг



Мал амьтныг гол халдварт өвчний үед  
Онцгой байдлын байгууллагын баримтлан  
ажиллах зааврын 3 дугаар хэсэрт



..... АЙМАГ /НИЙСЛЭЛ/ ..... СУМ /ДҮҮРЭГ/-ИЙН НУТАГТ ГАРСАН ..... ӨВЧНИЙ ТАРИЛГЫН МЭДЭЭ

Огноо

Д / Д	Сум, дүүргийн нэр	Тарилгад хамрагдвал зохих						Тарилгад хамрагдсан						Тарилга /мл/													
		Өрх	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Өрх	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Тарилгын явц /хувь/	Багийн тоо	Өрхийн тоо	Ажлын хэсэг	Малын эмч	Туслах ажилтан	НИЙТ	Анх авсан	Зарцуулсан	Эхэлсэн	Дууссан	Үлдэгдэл
1																											
2																											
Бүгд																											

Гарын үсэг